



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7700 7734, Факс: (976-11) 32 01 54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2018.03.14 № 769
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем

болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



С.ЭНХБААТАР

“НИЙСЛЭЛИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН
ХҮРЭЭЛЭН” ОНӨААТҮГ-ЫН 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

Аудитын тайлан

“Лидер экаунт аудит” ХХК
Захирал: П.Шаравхорол

Хавсралт 1: Агуулга

Чанарын хяналтын менежер
И.Юмчиндулам

Хавсралт 2: Аудитын тайлан

Хавсралт 3: Байгууллагаас ирүүлсэн хариу

Ахлах аудитор Д.Лхамсүрэн

Хавсралт 4: Менежментийн захидал

Цахим хаяг:
sharav_8054@yahoo.com

Хавсралт 5: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 6: Аудит хийгдсэн төсвийн
гүйцэтгэлийн тайлан

Утас: 70114519

Байршил: ЧД, 2-р хороо,
Төмөрчний гудамж 8-405

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТАБ	Төрийн аудитын байгууллага
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 18 дугаар зүйлийн 18.5-д Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд (НТАГ-2018/28/СТА-ОНӨААН) “Лидер экаунт аудит” ХХК гурван талт гэрээний үндсэн дээр аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, тухайн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Тус газар нь санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Нийслэл дэх Төрийн аудитын газрын үүрэг юм.

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 22-ноос 2018 оны 2 дугаар сарын 22-ны хооронд хийхээр төлөвлөн “Лидер экаунт аудит” ХХК-ийн аудитын багийн гишүүн ахлах аудитор Д.Лхамсүрэн, аудиторын туслах Ш.Уянга нар 2018 оны 2 дугаар сарын 1-нээс 2018 оны 2 дугаар сарын 28-ны хооронд хийж гүйцэтгэв.

Тус байгууллага нь 2017 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд 2018 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр 1/99 тоот албан бичгээр “Лидер экаунт аудит” ХХК-д ирүүлсэн.

Аудитын тайлан, гэрчилгээг 2018 оны 3 дугаар сарын 15-нд Нийслэлийн зураг төслийн хүрээлэнгийн удирдлагад хүргүүлж байна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Татварын ерөнхий хуулиуд болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулинд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

"Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн" ОНӨААТҮГ-ын дүрмийг НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 25 тоот тогтоолоор баталж мөрдүүлсэн байна.

Байгууллагын дүрмийн 4.2-т "Эрдэм шинжилгээ, хот байгуулалтын судалгаанд үндэслэн Бүс нутгийн хөгжлийн төсөл, хот төлөвлөлтийн суурь судалгаа, ТЭЗҮ, хот тосгоны болон шинэ хороолол, хотхоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн дэд бүтцийн болон авто зам, гүүрийн зураг төсөл, барилга байгууламжийн эх загвар, ажлын зураг төсөл боловсруулах" гэж тус байгууллагын үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлсон байна.

Дээрхи чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын захирал удирдана" гэж заасны дагуу "Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн" ОНӨААТҮГ-ын дарга хөрөнгийг захиран зарцуулж байна.

Тухайн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагааг ТАБ-СТА-А-1 маягтад тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 8-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн "Unicus" програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт

Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлд зааснаар өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд тус байгууллагын даргын 2017 оны А/28 тоот тушаалаар батлагдсан дотоод аудитын комисс хяналт тавьж ажиллаж байна.

Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

"Нийслэлийн зураг төслийн хүрээлэн" ОНӨААТҮГ нь 2017 оны зорилтот түвшний төлөвлөгөөнд борлуулалтын орлого 2,610,000.0 мянган төгрөг байхаар батлагдсан. Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлогоос 1,564,641.8 мянган төгрөг, бусад орлогоос 12,069.7 мянган төгрөгийг олж, төлөвлөгөөг 39,6 хувь буюу 1,033,288.5 мянган төгрөгөөр тасалсан байна.

2017 оны зорилтот түвшний төлөвлөгөөнд нийт зардлыг нийт 2,329,983.7 мянган төгрөг байхаар батлагдсан. Гүйцэтгэлээр борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 519,513.7 мянган төгрөг, ерөнхий удирдлагын зардалд 895,000.8 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардалд 42,757.90 мянган төгрөг, нийт 1,457,272.4 мянган төгрөгийг зарцуулж, 119,439.1 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны зорилтот түвшний төлөвлөгөө, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төлөвлөгөө, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 8 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

Тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 100.0 мянган төгрөгөөс дээш 2,778,264.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин хөлс, НДШ зэрэг дансны ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт мөнгөн хөрөнгийн 60 %, нийт зардлын 65 %, нийт хөрөнгийн 75 %-ийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад авлага, өглөг, бусад асуудалд материаллаг бус алдаа илэрсэн. Үүнд:

1. 2010-2013 онд үүссэн 131,661.5 мянган төгрөгийн он дамжсан авлага байгаагаас, “Хас харш” ХХК-аас авах 95,000.0 мянган төгрөг, “Монголын нутгийн удирдлагын холбоо” ТББ-аас авах 19,340.0 мянган төгрөгийн авлагыг 2017 оны жилийн эцсийн байдлаар тооцоо нийлж, баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6 дахь заалтыг мөрдөж ажиллах.

2. Тус байгууллагын даргын 2011 оны А/45 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Энэ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зайлшгүй байвал зохих бодлогын горимуудыг оруулж, шинэчлэх шаардлагатай байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсний дагуу байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зохих өөрчлөлтүүдийг оруулж, батлуулан бүртгэл, тайлагналыг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж хэвших.

Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 2 хувиар тооцож 29, 134.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитын явцад залруулах материаллаг алдаа тогтоогүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад дараагийн аудитаар авч үзэх материаллаг асуудал гараагүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудалгүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Хас харш” ХХК-аас авах 95,000.0 мянган төгрөг, “Монголын нутгийн удирдлагын холбоо” ТББ-аас авах 19,340.0 мянган төгрөгийн авлагыг 2017 оны жилийн эцсийн байдлаар тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар 2 зөвлөмж өгсөнөөс зураг төслийн үйлдвэрлэлийн онцлогоос хамаарч, газар олголт, техникийн нөхцөл шийдвэрлэгдэхгүй удсаны улмаас зураг төслийн барьцаа, үлдэгдэл хөрөнгө чөлөөлөгдөхгүй, санхүүжилт хойшлогдох зэрэг шалтгаанаас жил дамжин авлага үүсч, зураг төсөлтэй холбоотой гарсан шууд хөдөлмөр, шууд материал, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлуудыг ажлын захиалгын аргаар тооцох боломжгүй гэсэн үндэслэлээр зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Зөрчилгүй санал, дүгнэлт

“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 12 хуудас, хавсралтууд 20 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

Хоёрдугаар шатанд хянасан:


“Лидер экаунт аудит” ХХК-ийн
захирал



П.Шаравхорол

Анхан шатанд хянасан:

Чанарын хяналтын менежер



И.Юмчиндулам

Бэлтгэсэн:
Ахлах аудитор



Д.Лхамсүрэн

“НИЙСЛЭЛИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН ХҮРЭЭЛЭН” ОНӨААТҮГ-ЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Авлагын талаар 1

Асуудал 2

НББББичгийн талаар..... 2

Менежментийн захидал

“Лидер экаунт аудит” ХХК нь аудитын явцад илрүүлсэн зүйлсийн менежментийн захидлыг “Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Иймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

“Лидер экаунт аудит” ХХК-ийн энэхүү зөвлөмж танай бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай байгууллагын үүрэг юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Авлагын талаар**Тэргүүлэх ач олбогдол №1****Ажиглалт :**

2010-2013 онд үүссэн 131,661.5 мянган төгрөгийн он дамжсан авлага байгаагаас, “Хас харш” ХХК-аас авах 95,000.0 мянган төгрөг, “Монголын нутгийн удирдлагын холбоо” ТББ-аас авах 19,340.0 мянган төгрөгийн авлагыг 2017 оны жилийн эцсийн байдлаар тооцоо нийлж, баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6 дахь заалтыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор гаргаж Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд:

- Найдваргүй авлага нэмэгдэж хөрөнгө зүй бусаар зарцуулагдах
- Хууль зөрчигдөх

Үйлчлүүлэгчийн хариу

Өгсөн зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

Асуудал 2: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**Тэргүүлэх ач олбогдол №1****Ажиглалт :**

Тус байгууллагын даргын 2011 оны А/45 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Энэ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зайлшгүй байвал зохих бодлогын горимуудыг оруулж, шинэчлэх шаардлагатай байна.

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсний дагуу байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зохих өөрчлөлтүүдийг оруулж, батлуулан бүртгэл, тайлагналыг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж хэвших.

Эрсдэлүүд:

- Толилуулга ба илчлэл тодруулга, Үнэн зөв байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх,
- СТОУС, бусад хууль журам зөрчигдөх, Санхүүгийн тайлангийн мэдээлэл алдаатай, буруу илрхийлэгдэх эрсдэлтэй

Үйлчлүүлэгчийн хариу

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зохих өөрчлөлтүүдийг оруулж, бүртгэл, тайлагналыг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж хэвшүүлж ажиллана.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

Хоёрдугаар шатанд хянасан:


“Лидер экаунт аудит” ХХК-ийн
захирал



П.Шаравхорол

Анхан шатанд хянасан:

Чанарын хяналтын менежер



И.Юмчиндулам

Бэлтгэсэн:
Ахлах аудитор



Д.Лхамсүрэн

Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2017 оны 1 сарын1	2017 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	640,280,817.99	518,596,313.22
1.1.02	Дансны авлага	758,708,385.00	911,760,285.00
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	531,684.24	976,460.81
1.1.04	Бусад авлага	45,516,250.00	33,841,250.00
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.06	Бараа материал	20,715,805.10	33,593,615.91
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.09	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эрг-н бус хөрөнгө	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,465,752,942.33	1,498,767,924.94
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.01	Үндсэн хөрөнгө	166,987,850.72	146,235,142.31
1.2.02	Биет бус хөрөнгө	26,181,972.62	12,092,767.36
1.2.03	Биологийн хөрөнгө	-	-
1.2.04	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.05	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.07	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	193,169,823.34	158,327,909.67
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,658,922,765.67	1,657,095,834.61
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.01	Дансны өглөг	105,057,000.00	117,782,000.00
2.1.1.02	Цалингийн өглөг	-	-
2.1.1.03	Татварын өр	103,574,605.85	53,823,593.45
2.1.1.04	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.05	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.06	Хүүний өглөг	-	-
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.09	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.11	Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	208,631,605.85	171,605,593.45

2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.01	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.02	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	208,631,605.85	171,605,593.45
2.3	Эздийн өмч	-	-
2.3.01	Өмч: - төрийн	137,645,013.31	161,153,013.31
2.3.02	-хувийн	-	-
2.3.03	-хувьцаат	-	-
2.3.04	Халаасны хувьцаа	-	-
2.3.05	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.07	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	23,508,000.00	-
2.3.09	Хуримтлагдсан ашиг	1,289,138,146.51	1,324,337,227.85
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	106,292,831.81
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	1,289,138,146.51	1,218,044,396.04
2.3.09.3	Ногдол ашиг	-	-
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,450,291,159.82	1,485,490,241.16
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,658,922,765.67	1,657,095,834.61

Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,671,695,009.59	1,564,641,772.73
02	Борлуулалтын өртөг	468,548,445.12	519,513,685.92
03	Нийт ашиг (алдагдал)	1,203,146,564.47	1,045,128,086.81
04	Түрээсийн орлого	-	-
05	Хүүний орлого	5,104,846.84	12,024,247.93
06	Ногдол ашгийн орлого	-	-
07	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
08	Бусад орлого	914,045.45	45,454.55
08.1	Орлогын дүн	6,018,892.29	12,069,702.48
09	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	903,814,861.65	917,935,056.05
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	61,871,600.00	19,261,822.80
12.1	Зардлын дүн	965,686,461.65	937,196,878.85
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	1,916,305.97	(561,736.45)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
17.1	Олз, гарзын дүн	1,916,305.97	(561,736.45)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	245,395,301.08	119,439,173.99
19	Орлогын татварын зардал	30,726,690.05	13,146,342.18
20	Татварын дараах ашиг (алдагдал)	214,668,611.03	106,292,831.81
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	214,668,611.03	106,292,831.81
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлсөн капитал	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрв.нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2015 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	-	-
03	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	-	-
05	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
06	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-
07	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-	-
09	2016 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	137,645,013.31	-	-	-	-	-	1,289,138,146.51	1,426,783,159.82
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	23,508,000.00	-	-	-	-	-	(102,322,150.47)	(78,814,150.47)
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	106,292,831.81	106,292,831.81
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	31,228,400.00	31,228,400.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-	-
17	2017 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	161,153,013.31	-	-	-	-	-	1,324,337,227.85	1,485,490,241.16

Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,035,208,284.00	1,670,283,857.84
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,616,884,656.00	1,425,098,127.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	7,128,428.00	10,062,558.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	411,195,200.00	235,123,172.84
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,528,678,391.91	1,782,232,125.78
1.2.1	Ажиллагчдад төлсөн	462,051,231.97	414,158,127.99
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	105,561,748.29	120,773,314.41
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	20,235,347.00	13,253,860.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	40,269,631.00	19,104,840.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,950,000.00	6,970,000.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	150,516,596.99	266,368,876.72
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	9,864,356.00	1,523,447.55
1.2.9	Бусад мөнгөн зарлага	735,229,480.66	940,079,659.11
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	506,529,892.09	(111,948,267.94)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,324,846.84	11,499,463.17
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	3,220,000.00	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	5,104,846.84	11,499,463.17
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8	Бусад	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	69,021,300.00	21,235,700.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	69,021,300.00	21,235,700.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6	Бусад	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(60,696,453.16)	(9,736,236.83)

3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	31,228,400.00	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	31,228,400.00	-
3.2.5	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(31,228,400.00)	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	414,605,038.93	(121,684,504.77)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	225,675,779.06	640,280,817.99
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	640,280,817.99	518,596,313.22

Регистрийн дугаар: 5369568

Хаяг: Хангарьд ордон



Цуудангийн хаяг :

Утас:

Факс:

A

НИЙСЛЭЛ ЗУРАГ ТӨСЛИЙН ХҮРЭЭЛЭН /РД:5369568/-ИЙН
2017 ОНЫ 4-Р УЛИРЛЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Хянаж хүлээн авсан байгууллагын нэр	Сар, өдөр	Гарын үсэг
НХС	2018.02.09	
НСТСХ	11/14	

Нийслэл зураг төслийн хүрээлэн /РД:5369568/ 0

Тайлант огноо: 2017.12.31

Сангийн сайдын 2012 оны 77 тоот тушаалаар батлав

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Хэвлэсэн огноо: 2018.03.02 11:30:52

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2017 оны 1 сарын 1	2017 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	640,280,817.99	518,596,313.22
1.1.02	Дансны авлага	758,708,385.00	911,760,285.00
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	531,684.24	976,460.81
1.1.04	Бусад авлага	45,516,250.00	33,841,250.00
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.06	Бараа материал	20,715,805.10	33,593,615.91
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.09	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эрг-н бус хөрөнгө	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,465,752,942.33	1,498,767,924.94
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.01	Үндсэн хөрөнгө	166,987,850.72	146,235,142.31
1.2.02	Биет бус хөрөнгө	26,181,972.62	12,092,767.36
1.2.03	Биологийн хөрөнгө	-	-
1.2.04	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.05	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.07	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	193,169,823.34	158,327,909.67
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,658,922,765.67	1,657,095,834.61
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.01	Дансны өглөг	105,057,000.00	117,782,000.00
2.1.1.02	Цалингийн өглөг	-	-
2.1.1.03	Татварын өр	103,574,605.85	53,823,593.45
2.1.1.04	НДШ - ийн өглөг	-	-
2.1.1.05	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.06	Хүүний өглөг	-	-
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.09	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.11	Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	208,631,605.85	171,605,593.45
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.01	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.02	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	208,631,605.85	171,605,593.45
2.3	Эздийн өмч	-	-
2.3.01	Өмч: - төрийн	137,645,013.31	161,153,013.31
2.3.02	- хувийн	-	-
2.3.03	- хувьцаат	-	-
2.3.04	Халаасны хувьцаа	-	-
2.3.05	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.07	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	23,508,000.00	-
2.3.09	Хуримтлагдсан ашиг	1,289,138,146.51	1,324,337,227.85
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	106,292,831.81
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	1,289,138,146.51	1,218,044,396.04
2.3.09.3	Ногдол ашиг	-	-
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,450,291,159.82	1,485,490,241.16

Дарга:



Ч.Рэгзмаа

Нягтлан бодогч:

О.Бямбасүрэн

Нийслэл зураг төслийн хүрээлэн /РД:5369568/

Тайлант огноо: 2017.12.31

Сангийн сайдын 2012 оны 77 тоот тушаалаар батлав

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Хэвлэсэн огноо: 2018.03.02 11:33:57

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,671,695,009.59	1,564,641,772.73
02	Борлуулалтын өртөг	468,548,445.12	519,513,685.92
03	Нийт ашиг(алдагдал)	1,203,146,564.47	1,045,128,086.81
04	Түрээсийн орлого	-	-
05	Хүүний орлого	5,104,846.84	12,024,247.93
06	Негдлөл ашгийн орлого	-	-
07	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
08	Бусад орлого	914,045.45	45,454.55
08.1	Орлогын дүн	6,018,892.29	12,069,702.48
09	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	903,814,861.65	917,935,056.05
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	61,871,600.00	19,261,822.80
12.1	Зардлын дүн	965,686,461.65	937,196,878.85
13	Гаднад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	1,916,305.97	-561,736.45
15	Бусад бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
17.1	Олз гарзын дүн	1,916,305.97	-561,736.45
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	245,395,301.08	119,439,173.99
19	Орлогын татварын зардал	30,726,690.05	13,146,342.18
20	Татварын дараах ашиг (алдагдал)	214,668,611.03	106,292,831.81
21	Элгээрсөн үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	214,668,611.03	106,292,831.81
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гаднад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

Дарга:

Ч.Рэгзмаа

Нягтлан бодогч:

О.Бямбасүрэн



Нийслэл зураг төслийн хүрээлэн /РД:5369568/

Тайлант огноо: 2017.12.31

Сангийн сайдын 2012 оны 77 тоот тушаалаар батлав

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Хэвлэсэн огноо: 2018.03.02 11:37:16

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлсөн капитал	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрв.нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2015 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	-	-
03	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	-	-
05	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
06	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-
07	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-	-
09	2016 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	137,645,013.31	-	-	-	-	-	1,289,138,146.51	1,426,783,159.82
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	23,508,000.00	-	-	-	-	-	-102,322,150.47	-78,814,150.47
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	106,292,831.81	106,292,831.81
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	31,228,400.00	31,228,400.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-	-
17	2017 оын 12 сарын 31-р үлдэгдэл	161,153,013.31	-	-	-	-	-	1,324,337,227.85	1,485,490,241.16

Дарга:

Ч.Рэгзмаа

Нягтлан бодогч:

О.Бямбасүрэн



Нийслэл зураг төслийн хүрээлэн /РД:5369568/

Тайлант огноо: 2017.12.31

Сангийн сайдын 2012 оны 77 тоот тушаалаар батлав

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хэвлэсэн огноо: 2018.03.02 11:42:49

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,035,208,284.00	1,670,283,857.84
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,616,884,656.00	1,425,098,127.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	7,128,428.00	10,062,558.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	411,195,200.00	235,123,172.84
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,528,678,391.91	1,782,232,125.78
1.2.1	Ажиллагчдад төлсөн	462,051,231.97	414,158,127.99
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	105,561,748.29	120,773,314.41
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	20,235,347.00	13,253,860.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	40,269,631.00	19,104,840.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,950,000.00	6,970,000.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	150,516,596.99	266,368,876.72
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	9,864,356.00	1,523,447.55
1.2.9	Бусад мөнгөн зарлага	735,229,480.66	940,079,659.11
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	506,529,892.09	-111,948,267.94
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,324,846.84	11,499,463.17
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	3,220,000.00	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	5,104,846.84	11,499,463.17
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8	Бусад	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	69,021,300.00	21,235,700.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	69,021,300.00	21,235,700.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6	Бусад	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-60,696,453.16	-9,736,236.83
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	31,228,400.00	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	31,228,400.00	-

3.2.5	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-31,228,400.00	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	414,605,038.93	-121,684,504.77
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	225,675,779.06	640,280,817.99
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	640,280,817.99	518,596,313.22

Дарга:

Ч.Рэгзмаа

Нягтлан бодогч:

О.Бямбасүрэн

